



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020. 08. 13 № 534

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН БАЯН-УУЛ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БАЯН-УУЛ
СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ДАРГА Г.ГАНЧИМЭГ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Баян-уул сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Баян-уул сумын Монгол ардын нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Баян-уул сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

"Баян-уул сумын Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3. дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Баян-уул сумын Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр /02 хуудас/-ыг хавсаргав.

Хувийг: Аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт . 02 хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Б.БОЛОРТУУЛ



Баян Уул сумын Монгол Ардын Намын хорооны
бүх гишүүдийн 2020 оны 26 сарын 26-д
дүгээр хуралдааныг дугаар тогтоолын хавсралт

Баян-Уул сумын Монгол Ардын Нам орон нутгийн сонгуульд
оролцох мөрийн хөтөлбөр



Баян-Уул сумын Монгол Ардын Намын хорооны 2020-2024 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн 2 бодлогын 5-н
бүлгийн хүрээнд нийт 16 зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлж байна. Үүнд:

№	Зорилт	Хугацаа	Санхүүгийн эх үүсвэр	Хариуцах эзэн
Нэг : НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД				
1. Эрүүл мэнд, спортын чиглэлээр				
1.1	Сум дундын хүн эмнэлэгийн өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлэх.	2021-2024 онд	Улсын төсөвийн хөрөнгөөр 630,000 сая төгрөг /зураг төсөв нь хийгдсэн	ИТХурлын дарга Сумын засаг дарга
1.2	Сум дундын хүн эмнэлэгийн барилгын их засвар	2021-2022 онд	Улсын төсөвийн хөрөнгөөр 310,000 сая төгрөг /зураг төсөв хийгдсэн /.	ИТХурлын дарга Сумын засаг дарга
1.3	4, 5 р багт хүүхдийн тоглоомын талбайг шинээр байгуулах	2021онд	Бусад эх үүсвэр болон тусламжаар 50, 0 сая төгрөг.	Сумын Засаг даргын орлогч
1.4	Хуучин соёлын төвийн барилгыг спорт заал болгон ашиглахад их засварын ажил хийгдэх	2021-2024	Улсын төсөвийн хөрөнгөөр 266,0 сая төгрөг	Аймгийн Засаг даргын орлогч Сумын засаг дарга
2. Боловсрол, соёл урлагийн чиглэлээр				
2.1	Бэрх багийн цэцэрлэгийн бүлгийн их засвар, өргөтгөлийн ажлыг хийх.	2021-2022 онд	Бусад эх үүсвэр, тусламж 311,0 сая төгрөг	Сумын Засаг даргын орлогч
2.2	Ерөнхий боловсролын сургуулийн 150 хүүхдийн дотуур байр барих	2021-2024 онд	Улсын төсөвийн хөрөнгөөр 1,689,000 төгрөг /зураг төсөв нь хийгдсэн /.	Сумын засаг дарга

2.3	Сумын Соёлын төвийн барилгыг шинээр барих ашиглалтанд оруулах	2020-2021 онд	Улсын төсөвийн хөрөнгөөр 1,769,000 төгрөг	Сумын засаг дарга
Хоёр : ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД				
1.Хөдөө аж ахуйн чиглэлээр				
1.1	Инженерийн хийцтэй, гүн өрмийн худаг гаргах ажлыг зохион байгуулах.	2020-2024 онд	Улсын төсөвийн хөрөнгөөр Жилд 2 худаг 20,0 сая төгрөг	Сумын засаг дарга
1.2	Сумын төвд хүнсний ногооны зoorийг шинээр барих	2021-2024 онд	Бусад эх үүсвэр болон тусламжаар 90, 0 сая төгрөг	Сумын Засаг даргын орлогч
1.3	Хөдөөгийн Заяат баг. Урт багийн нутаг дэвсгэрт мал угааврын ванн шинээр барих	2021-2023 онд	Бусад эх үүсвэр болон тусламжаар 50, 0 сая төгрөг	Сумын Засаг даргын орлогч
1.4	Хар чулуут, Өвөр Эрзэн багийн мал угааврын ванны засвар	2021-2024 онд	Бусад эх үүсвэр болон тусламжаар 20, 0 сая төгрөг	Сумын Засаг даргын орлогч
2 Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр				
2.1	Булаг шандын эхийг хашиж хамгаалах	2021-2024 онд	Бусад эх үүсвэр болон тусламжаар 20, 0 сая төгрөг.	Аймгийн Засаг даргын орлогч
3. Дэд бүтцийн чиглэлээр				
3.1	Бохир соруулж зайлуулах зориулалтын машин худалдан авах.	2021-2024 онд	Бусад эх үүсвэр болон тусламжаар 40, 0 сая төгрөг.	Сумын Засаг дарга
3.2	Сумын төвийн 3 км замыг асфалтан зам болгох, борооны ус зайлуулах шугам тавих.	2021-2024 онд	Улсын төсөвийн хөрөнгөөр 900,0 сая төгрөг	Аймгийн Засаг даргын орлогч
3.3	Сумын төвийн Эрчим хүчний шугам сүлжээний толгой дэд станцын өргөтгөл хийх	2021-2024 онд	Улсын төсөвийн хөрөнгөөр 500,0 сая төгрөг	Сумын засаг дарга
3.4	Сум Дундын цагдаагийн тасгийн кобоны барилга шинээр барих	2021-2024 онд	Улсын төсөвийн хөрөнгөөр 398,0 сая төгрөг	Сумын засаг дарга

Боловсруулсан

Б. Чимгээ

Хянасан намын хорооны дарга

Г. Ганчимэг